

# ЦАХИМ АЛБАН БИЧИГ СОЛИЛЦООНЫ “СМАРТ ОФФИС” СИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

Монгол Улс, Улаанбаатар хот

## 1. ТООН ГАРЫН ҮСЭГ

1. СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧ НЬ МОНГОЛ УЛСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨЖ БҮЙ ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ МӨРДЛӨГ БОЛГОН АЖИЛЛАНА.

2. Системийн хэрэглэгч нь тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч байгууллагаас \ГОб\ э-токен төхөөрөмжөө авч тоон гарын үсгийн гэрчилгээг суулгасан байна. ГОб-ын мэдээллийг <http://cita.gov.mn/?p=12031> цахим хуудаснаас авна уу.

Одоогоор системд

- “ТРИДУМ э-СЕКЬЮРИТИ” ХХК

- “МОНПАСС СА” ХХК

- “НЬЮКОМПАС” ХХК

- “ВИЭСЭМ” ХХК -аас

олгосон тоон гарын үсгийг ашиглана.

3. “Смарт Оффис” системд бүртгүүлсэн тоон гарын үсэг эзэмшигчийг тухайн аж ахуйн нэгж байгууллагыг бүрэн төлөөлнө гэж үзнэ.

4. Системийн хэрэглэгч нь явуулж буй цахим материал тус бүрт 1 удаа Системд бүртгэгдсэн тоон гарын үсгийг зурж, баталгаажуулсан байна.

5. Цахим албан бичгийг уламжлалт байдлаар гарын үсэг зурж, тамга дарсан эсвэл системээр боловсруулагдсан байх ба заавал эрх бүхий хуулийн этгээдийг төлөөлөх тоон гарын үсгийг зурсан байна.

6. “Смарт Оффис” системд зөвхөн .pdf өргөтгөлтэй файл ашиглана.

7. Тоон гарын үсэг болон цахим албан бичиг дэх мэдээллийн үнэн бодит байдлыг хэрэглэгч бүрэн хариуцна.

## 2. “СМАРТ ОФФИС” СИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Энэхүү систем нь Монгол Улсын цахим албан бичиг солилцооны нэгдсэн системд холбогдсон бүхий л байгууллага хооронд тоон гарын үсгээр баталгаажсан цахим албан бичиг, цахим файл солилцох зориулалтаар ашиглагдана.

2. Үйлчилгээний нөхцөл нь нэг талаас “Смарт Оффис” системийн аюулгүй, найдвартай байдлыг ханган хэрэглэгчийн мэдээллийг хадгалах, хамгаалах, үйлчилгээг үзүүлэх, нөгөө талаас өөрийн байгууллагын албан хэргийн баримт бичгийг хөтлөх, боловсруулах, хянах, харилцагч байгууллага хооронд солилцох, архивлах талуудын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

3. Үйлчилгээний нөхцөл нь хэрэглэгч тал үйлчилгээний нөхцөлтэй танилцан хүлээн зөвшөөрч, “Смарт Оффис” системийг хэрэглэхийн тулд бүртгүүлсэн өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

4. Хэрэглэгч тал нь системд оруулсан бүхий л өгөгдөлд хамаарах оюуны болон өмчлөх эрхийг эзэмшинэ.

5. Үйлчилгээ үзүүлэгч тал нь “Смарт Оффис” системтэй холбоотой өгөгдлөөс бусад бүхий л оюуны болон өмчлөгч эрхийг эзэмшинэ.
6. Үйлчилгээтэй холбоотой техник, технологи, хадгалагдаж буй бүх мэдээлэл нь үйлчилгээ үзүүлэгч талын нууц бөгөөд Монгол улсын “Байгууллагын нууцын тухай” хуулиар зохицуулагдана.

### 3. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1. Хэрэглэгч тал нь үйлчилгээний нөхцөлтэй танилцаж зөвшөөрснөөр дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.
2. Системийн алдаа доголдлыг засварлахыг шаардах эрхтэй.
3. Системд аюултай байж болох элдэв файл дамжуулахгүй байх үүрэгтэй.
4. Албан бичиг нь холбогдох албан хэрэг хөтлөлтийн MNS:5140 стандартыг хангасан байх.
5. Албан бичиг хүлээн авагч тал стандартын шаардлага хангаагүй болон бусад шалтгаанаар албан бичгийн илгээгч талд буцаах, үүнтэй холбоотой зөрчил бүртгэх эрхтэй.
6. Системийн үйл ажиллагаа болон процессыг ашиг олох зорилгоор хуулах, эрх шилжүүлэх, кодыг засварлах, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.
7. Систем дэх бүхий л хэрэглэгчийн мэдээллийн нууцлах үүрэгтэй.
8. Өөрийн нууц үгийг алдалгүй, найдвартай хадгалах үүрэгтэй.
9. Өөрийн нууц үгээ өөрчлөх, шинэчлэх нь хэрэглэгчийн үүрэг байна.
10. Системд сэжиг бүхий доголдол гарсан бол үйлчилгээ үзүүлэгч талд мэдэгдэх үүрэгтэй.
11. Хэрэглэгч тал нь үйлчилгээ үзүүлэгч талын компьютерын сүлжээ, сервер компьютерт хууль бусаар халдах, үйлчилгээнд эвдрэл, саатал учруулах оролдлого хийхгүй байх үүрэгтэй.

### 4. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1. Хэрэглэгч талд тоног төхөөрөмжийн болон аюулгүй байдлын заавар зөвлөгөө өгөх, санал болгох эрхтэй.
2. Систем нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид заасан чанарын шаардлага хангасан байна.
3. Системийг ашиглах гарын авлага заавар, зураг, схемээр хангах үүрэгтэй.
4. Үйлчилгээ үзүүлэгч тал нь “Смарт Оффис” системийн арчилгаа, аюулгүй найдвартай байдал, хэрэглэгчийн мэдээлэл болон үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, хамгаалах зэрэг үйл ажиллагааны жигд байдлыг хангах үүрэгтэй.
5. Үйлчилгээ үзүүлэгч тал нь ажлын цаг болох 09.00-18.00 цагийн хооронд (Даваа-Баасан гаригт) үйлчилгээний нөхцөлийн дагуу зөвлөх үйлчилгээг хэрэглэгч талд хүргэнэ.
6. Үйлчилгээ үзүүлэгч тал нь хэрэглэгчийн мэдээлэлд шууд хандалт хийхгүй бөгөөд хэрэглэгч талын зөвшөөрсөн урилгын дагуу хэрэглэгчийн мэдээлэлд хандаж тусламж, зөвлөгөө өгнө.

7. Үйлчилгээ үзүүлэгч тал нь хэрэглэгчийн байгаа байрлалд биечлэн очиж тусламж, дэмжлэг үзүүлэхгүй.
8. Үйлчилгээ үзүүлэгч тал нь техникийн өргөтгөл, програмын өөрчлөлт, шинэчлэлт хийх тохиолдолд үйлчилгээнд түр хугацааны зогсолт хийнэ. Энэ тохиолдолд хэрэглэгчийн мэйл хаяг болон веб сайтаар дамжуулан урьдчилан мэдэгдэнэ.
9. Үйлчилгээ үзүүлэгч тал нь үйлчилгээний нөхцөлийг өөрчлөн, шинэчлэх эрхтэй. Үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт хийхээс ажлын 3 хоногийн өмнө өөрчлөлтийн мэдэгдлийг хэрэглэгчийн мэйл хаяг болон веб сайтаар дамжуулан мэдэгдэнэ.

## **5. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

1. Хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үг алдагдсан тохиолдлоос үүдэх хохирол, аливаа асуудлыг үйлчилгээ үзүүлэгч тал хариуцахгүй.
2. Хэрэглэгч тал нь үйлчилгээг ашиглан хийсэн бүхий л үйлдэлд хариуцлага хүлээнэ.
3. Програмын өөрчлөлт, шинэчлэлт хийсэнтэй холбоотой хэрэглэгчийн мэдээлэл өөрчлөгдсөн, утсан тохиолдолд хариуцлагыг үйлчилгээ үзүүлэгч тал хүлээх бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд талууд хамтран ажиллана.
4. Үйлчилгээ үзүүлэгч тал нь хэрэглэгч талын интернет холболтоос үүдэлтэй асуудлын хариуцлагыг хүлээхгүй.
5. Аль ч тал үйлчилгээний хэрэгжилт, бусад талуудын үйлчилгээний талаарх үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
6. Системийг хэрэглэгч байгууллагууд нь зөрчилтэй албан бичиг илгээсэн эсвэл шийдвэрлүүлэхээр илгээсэн албан бичгийг заасан хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд хариуцлагыг үйлчилгээ үзүүлэгч тал хариуцахгүй.

## **6. АСУУДАЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

1. Үйлчилгээ үзүүлэгч тал нь үйлчилгээг ашиглахтай холбоотой санал, гомдол, хүсэлтийг smartofficemn@gmail.com имэйл хаяг болон 7575-7878, 89210319, 99924847 утсаар (ажлын өдрүүдэд 09:00 - 18:00 цагийн хооронд) хүлээн авч шийдвэрлэнэ.
2. Үйлчилгээний тасалдал нь байгалийн давагдашгүй хүчин зүйл (гал, үер, газар хөдлөлт, аянга болон тэсрэлт) эсвэл төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан хуулийн зохицуулалт, журам, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, ажил хаялт, дайн, террорист халдлага, гоц халдварт өвчин зэрэгтэй холбоотой бол үйлчилгээг тасалдсанд тооцохгүй бөгөөд үйлчилгээ үзүүлэгч тал хариуцлага хүлээх үндэслэл болохгүй.
3. Хэрэглэгч тал нь үйлчилгээний нөхцөлөөр хүлээсэн үүргээ зөрчсөн, үйлчилгээг хууль бусаар ашигласан, үйлчилгээ үзүүлэгч талын үйл ажиллагаанд болон бусад хэрэглэгчдэд хохирол учруулсан нь батлагдвал хэрэглэгчийн нэвтрэх эрхийг цуцална.
4. Үйлчилгээтэй холбоотой санал, гомдол, асуудал, маргааныг талууд эв, зүйгээр харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Хэрэв шийдвэрлэх боломжгүй бол Монгол Улсын хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

## 7. БУСАД

1. Үйлчилгээний нөхцөлийг тоон гарын үсгээр баталгаажуулна.
2. Талуудын харилцан тохиролцсон саналаар үйлчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
3. Үйлчилгээний нөхцөлийн нэмэлт өөрчлөлт болон хавсралт нь үйлчилгээний салшгүй хэсэг мөн болно.
4. Талууд үйлчилгээний нөхцөлөөр хүлээсэн эрх үүргээ бусдад шилжүүлэхийг хориглоно.
5. Энэхүү үйлчилгээгээр олж авсан болон үйлчилгээний хүчинтэй хугацаанд шууд болон шууд бусаар олж авсан бүхий л мэдээллийг задруулахыг хориглоно.
6. Энэхүү үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулна.

## 8. ҮГ, ХЭЛЛЭГИЙН ТАЙЛБАР

Үг хэллэг	Тайлбар
“Смарт Оффис” систем	СМАРТ ОФФИС ХХК-ийн бүтээгдэхүүн болох цахим албан хэрэг хөглөлтийн систем
Үйлчилгээ	“Смарт Оффис” системийн ашиглах үйлчилгээ
Үйлчилгээ үзүүлэгч	Смарт оффис системийг хариуцан, үйлчилгээ үзүүлж буй НЬЮСОНИК ХХК
Үйлчилгээний нөхцөл	Үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулах баримт бичиг
Үйлчилгээний хугацаа	Үйлчилгээний хугацаа нь хэрэглэгч өөрийн хүсэлтээр үйлчилгээг зогсоох хүртэл үргэлжилнэ.
Хэрэглэгч	Смарт оффис системийг ашиглаж буй аж ахуйн нэгж, эсвэл хуулийн этгээдийг төлөөлөгч хүн
Хэрэглэгчийн мэдээлэл	Хэрэглэгчийн хувийн мэдээлэл болон хэрэглэгчийн оруулсан бүртгэлийн мэдээлэл
Талууд	Үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгч
Сервер компьютер	Үйлчилгээнд ашиглагдаж буй өндөр хүчин чадал бүхий тусгай зориулалтын компьютер
Гуравдагч этгээд	Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг хангах мэдээллийг агуулагч болон Хэрэглэгчийн зөвшөөрсөн мэдээллийг хүлээн авагч байгууллага буюу хуулийн этгээд

Энэхүү үйлчилгээний нөхцөл нь үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулна. Үйлчилгээний нөхцөлтэй танилцаж, зөвшөөрснөөр үйлчилгээтэй холбоотой харилцаанд оролцох эрх, үүрэг, хариуцлагыг хүлээхээр талууд тохиролцсонд тооцогдоно.